

# Амьс дугаар ТАВАН ЖИЛ

ТӨВ АЙМГИЙН НАМЫН ХОРОО,  
АДХ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ СӨНИН.

13 дэх жилдээ 1961 оны  
54 (10102) 7 дугаар сарын 11 МЯГМАР

## Яруу алдарт түүхт 40 жил

Өнөөдөр манай жаргалант эх оронд ардын хувьсгал ялж мандсаны түүхт 40 жилийн ойг баярыг монголын хөдөлмөрчид найрамдаат орнуудын ард түмний хамт баяр баясгалантайгаар тэмдэглэж байна.

40 жилийн өмнө дотоодын эр шар феодалууд, гадаад империалистуудын дахир дараалын дор хамгийн хоцрогдсон тархай бутархай бүдүүлэг арга ажиллагаатай мал аж ахуйн орон байн.

Ард түмний аж амьдрал туушын дорой, соёл боловсролын талаар харанхуй бүдүүлэг, янз бүрийн хэлбэртэй харгислалд нэрвэгдэн гаслан зовж байсан юм.

1917 онд орос оронд октябрийн социалист их хувьсгал ялж эвлэлт засаг тогтсон явдал нь феодалын ба хөдөлмөрчид дарлалын эсрэг үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэж байсан орнуудын ард түмний тэмцэлд шийдвэрлэх нөлөө үзүүлсэн юм.

Энэ учраас 1921 онд марксист-ленинзмын сургаалаар удирдлага болгосон МАХН-ыг манай ард түмний шийдэлт хүү Сүхбаатар, Чойбалсан нар байгуулж ард түмний тэмцлийг удирдан жолоодож 1921 оны 7 дугаар сарын 11-нд ардын эрх зэргийг явуулав.

Энэ өдрөөс эхлэн монголын ард түмний түүхэнд саруул зам нээгдэж, энэ 40 жилийн дотор МАХН-ынхаа удирдлагын дор өөрийн оронд социализмыг өрнүүлж байгуулах шинэ үед дэвхсэн орлоо хөгжсөн.

Манай улсад хүнд, хөнгөн аж үйлдвэр хөгжиж үйлдвэрийн бүтээгдэхүүн 1940 оноос 1960 онд 7,4 дахин өссөн.

Хувьсгалын ялалтуудад орчин үеийн тээвэр, харилцаа холбоо шинээр хөгжиж их амжилт олон.

Манай улсын хөдөө аж ахуй түргэн хөгжиж 337 нэгдэл, орчин үеийн техникээр хангагдсан 28 сангийн аж ахуй, 38 МААМ станц-цеас бүрдсэн нэгдэл социализмт аж ахуй болжээ.

Атар газар эзэмшсэн үндсэн дээр 1960 онд 16 сая нүүр үр тариа хурал авч эх орны гурилын хэ-

рэгцээг хангаад гадаадад үр тариа гаргадаг болов.

Ард түмний аж амьдрал соёлын хэмжээ өдрөөс өдөрт өсөн дээшилсээр байна.

Хүн амын өсөлт хурдсаж 1960 онд 1000 хүн ам дутамын нэвэр өсөлт 32,8 хувь болжээ.

Манай улсад соёл шинжлэх ухаан хурдан янцаар хөгжиж дээд дунд боловсролтой, мэргэжилтэн, эрдэмтний тоо өсч шинжлэх ухааны салбар биеэ дааж ажиллах бололцоотой болж БНМАУ-ын шинжлэх ухааны академийг байгуулав.

Одоо 10000 хүн дутмаас 73-хүн дээд сургуульд суралцаж байгаа нь Итали, Япон, Холбооны Бүгд Найрамдах Германи зэрэг капиталист орныхоос давж байна.

Манай аймгийн хөдөлмөрчид нам засгийнхаа удирдлагын дор аж ахуй, соёлын талаар өнгөрсөн хугацаанд гяалалсан сайхан амжилтуудыг оллоо.

1961 оны эхний хагаст манай аймгийн малын төл бойжилт 95,4 хувь, тариа ногооны тариалалт 107,9 хувь, мал бэлтгэл 100,1 хувиар биелэгдээд байна.

Үйлдвэр, хорингоол, тээвэр, харилцаа холбооны байгууллагууд 1961 оны эхний хагас жилийн төлөвлөгөөг 6,1-35 хувиар давуулан биелүүлсэн байна.


Түүнчлэн соёл нэгээрэл, эрүүлийг хамгаалах Зарга хэмжээгүүд нэгэн адил биелэгдээ.

Ийм сайхан амжилтаа манай аймгийн хөдөлмөрчид улс хувьсгалынхаа 40 жилийн ойдоо бэлэг барна.

Манай аймгийн хөдөлмөрчид дургуй ард түмний МАХН-ынхаа 14 дүгээр их хурмын дэргэд шийдвэрийн баяртай хүлээн авч улам зоригжин 3 дугаар таван жилийн төлөвлөгөө, түүний эхний жил 1961 оны төлөвлөгөөт зорилтуудыг биелүүлэхэд зориг тэвгддөр байна.

Монгол Ардын Хувьсгалын яруу алдарт 40 жилийн ой манатугай!

МАХН-ынхаа мэргэн удирдлагын дор социализм өдл урагшаа!



## Их хурлынхаа шийдвэрийг хүлээн авч байна

## Баярын хурал

МАХ Намын 14 дүгээр их хурлын түүхт шийдвэрийг аймгийн төв, сум-нэгдэл, сангийн аж ахуйд хөдөлмөрчдийн цуглаанаар баяртай хүлээн авч байна.

Аймгийн төвийн ажилчин албан хаагчид ийн хөдөлмөрчдийн цуглаан болж МАХ Намын 14 дүгээр их хурлын түүхт шийдвэрийг баяртай хүлээн авлаа.

Цуглаан дээр аймгийн намын хорооны суртал ухуулгын хэлтсийн дарга Жамбал, намын 14 дүгээр их хурлын дүгийн тухай товч ярьв.

Цуглаанд оролцогчид дотроос эвлэлийн хорооны ажилтан Цэндэсрэн, хувсний комбинатын ажилтан Цэндэсрэн, 13 дугаар авто базаны СХТ бригадын ажлагч Жалдамбаа нарын олон хүн үг хэлж тодорхой үүрэг ашигаар.

Цэндэсрэн хэлэхдээ: их хурлынхаа шийдвэрийг баяртай хүлээн авч байна гээд комбинатынхаа замт олныг төлөөлж 3 дугаар 5 жилийн төлөвлөгөөг 1 жилийн өмнө давуулан биелүүлнэ гэж үүрэг авав.

Х. Түмэнбаяр

Монгол Ардын Хувьсгалын яруу алдарт 40 жилийн ойд зориулсан аймгийн төвийн нам, улс олон нийтийн байгууллагын төлөөлөгчид, хөдөлмөрчдийн баярын хурал 7 дугаар сарын 9-нд соёлын ордонд боллоо.

Баярын хуралд аймгийн намын хорооны 1 дүгээр нарийн бичгийн дарга С.РАГ-ЧАА үг хэлж нээв.

Баярын хурлын илтгэлийг аймгийн АДХГ захиргааны дарга Ц.ЖАМСРАН хийлээ.

Дараа нь: аймгийн намын хороо, АДХГ захиргаанаас ардын хувьсгалын 40 жилийн ойг угтаж ажил хөдөлмөрөөрөө шалгарсан тэргүүний хүмүүсийг шагнав.

Хурлын дараа аймгийн соёлын ордны жүжигчид, сайн дурын уран сайхандаас ардын хувьсгалын 40 жилийн ойд бэлтгэсэн концерт тоглоов.

# Манай аймгийн хөдөлмөрчид их

## Гурван төрийн нүүр

Би Бадаргуулах төрийн 16 дугаар он буюу 1891 онд төрсөн юм.

Төр төр намайг ид залуу байхад мөхөж, автономит төр байгуулагдсан. Энэ төрүүдийн үед манай ард түмэн хөдөлмөрлөх, сурч, боловсрох талаар бүрэн эрхгүй, монгол бичиг муу мэддэг, сампингийн эрх эргүүлдэг хүнийг их эрдэмтэн гэж нэрлэдэг байв.

1921 онд ардын гэгээн засаг мандаж ард түмэн манай эрх чөлөөгөө олж авсан төр өдрөөс эхлэн бийний энэ амьдралын сарууд зам нээгдсэн юм.

Манай улс энэ 40 жилд танигдашгүй болтлоо хөгжлөө.

1923 онд Улаанбаатар ардын үр хүүхдийг сургах 2 сургууль байсны нэг нь оюутны сургууль байлаа.

Би энэ оюутны сургуульд 1 жил суралцаж багшлах эрхийг олж авсан юм.

Тэгээд би Шанзав яамны дэргэдэх Шавийн бага сургуульд 1924 оноос эхлэн багшласнаас хойш одоо хүртэл ардын гэгээрдийн байгууллагад 37 жил тасралтгүй ажиллаж ирлээ.

Би энэ хугацаанд овойж төвийсон зүйл бүтээгээгүй боловч миний өмүүхэн хө-

дөлмөрийг хайрт, нам засаг маань өндөрөөр үнэлж төрийн дээд шагнал одон медалаар шагнаж, санхуйн БНМАУ-ын гавьяат багш гэдэг хүндэт цолоор шагналаа.

Одоо би 70 нас хүрлээ. Ингээд туулж өнгөрүүлсэн замаа эргэн харахад гурван төрийн нүүрийг үзсэн байх юм.

Тэхдээ манай хувьсгалт төр шиг ард түмнээ энхрийлэн хайрлаж тэдний сайн сайхны төлөө цаг үргэлж санаа тавьж байдаг төр байсангүй.

Ганцхан жиншээ дурдахад хувьсгалаас өмнө монголд бичиг үсэг мэддэг хүн байхгүй шахам байсан бол одоо цөм бичиг үсэгтэн болжээ.

Зөвхөн одоо ерөнхий боловсролын 400 гаруй сургуульд ардын 110 мянгаад хүүхдүүд охид суралцаж байна.

Би хэдийгээр өндөр настай болсон ч гэсэн эх орон ард түмнийхээ тусын тулд чадлынхаа хирээр ажиллана.

БНМАУ-ын гавьяат багш, аймгийн 10 жилийн дунд сургуулийн орлогч захирал **Ж. Намсрай**

## Төлөвлөгөөгөө давуулав

Эмийн сангийн ажилтан ажилчин 1961 оны эхний хагас жилийнхээ эм борлуулалтын төлөвлөгөөг 133,5 хувиар биелүүллээ.

Цэвэр эрхлэгчтэй Архустын эмийн сан төлөвлөгөөг сар бүр 167,5-249,8 хувь, хагас жилээр 201,6 хувь, Намсрайжав эрхлэгчтэй Жаргалантын эмийн сан 147,8 хувиар тус тус биелүүлжээ.

Д. ШАРАВ-ИШ

## Манай аймаг 1961 оны эхний хагас жилд

Б. Пэрэн (Аймгийн АДХГ Захиргааны нэгдүгээр орлогч)

сумд, Жаргалант, Архуст зэрэг сангийн аж ахуйнууд хаврын тариалалтын ажилд бусдаасаа давуутай ажиллав.

Манай аймгийн ХАА-н нэгдлүүд орон нутгийн материалыг ашиглаж малдаа тохилго дулаан хашаа саравч 522-ыг энэ хагас жилд шинээр бариллаа.

Тус аймагт хөдөө аж ахуйд хийгдсэн нэг арга хэмжээ бол аймгийн бүх малд эрүүл мэндийн үзлэг явуулж шилээт сонголт хийж өвчтэй малыг тусгаарлан эмчлэж байгаа явдал мөн.

Түүнчлэн нутгийн үүдрийн нилмэл хэсгээр хонь үхрийн үржлийн ферм байгуулж ажил оруулав.

ХАА-н талаар гарсан дээрх амжилтуудын уг сурвалж бол хөдөө аж ахуйд ажиллаж байгаа манай эрлэх хөдөлмөрчид хайрт эх орныхоо бүтээн байгуулалтын их үйлст эзэн хүний ёсоор ажиллаж социализ-



ЗУРАГ ДЭЭР: Авто тээврийн 13 дугаар баазын СХТ бригадын ахлагч Сампил тээвэрт явж ирээд бригадынхаа гишүүдтэй уулзаж байна.

Д. Дондогдоржийн гэрэл зураг

## 104 хувиар

Дэлгэрхаан сумын хувьсгалын бэлтгэлийн ангийн дэлгүүрийн худалдагч намын гишүүн Хишингтогтох ардын хувьсгалын 40 жилийн ойг угтаж шуурхай ажиллан эхний хагас жилийн бараа борлуулах төлөвлөгөөг 10 хоногийн өмнө 104,9 хувиар биелүүлэв.

Хишингтогтох хөдөлмөрчдөд түргэн үйлчлэх

## Их ойгоо угтсан амжилт

Аймгийн банкны хэлтсийн хамт олгоос ардын хувьсгалын 40 жилийн ойг угтаж социалист уралдаанд авсан үүргээ амжилттай биелүүлэхээр чармайн ажилласны үрээр 1961 оны эхний хагас жилд кассын төлөвлөгөөний орлогын ангийг 111,1 хувиар биелүүлж, зарлагыг 7 хувиар хэмнэжээ.

Орсон бүх орлогын 93 хувийг мөнгө хураагчдын ху-

чээр хурааж бэлэн мөнгө цуглуулах төлөвлөгөөгөө 115,5 хувиар биелүүлэв.

Мөнгө хураагч Доржпүрэв, Шаслар, Батдорж нар эхний хагас жилд хувиартай чиглэлүүдээсээ худалдааны орлого хураах төлөвлөгөөгөө 107,4-131,7 хувиар биелүүлж их ойгоо угтсан ажилдаа амжилт гаргав.

ЧУЛТЭМСҮРЭН

зорилгоор гурил, будааны авдрын хажуу талын доод хэсэгт гоожуулах

төмөр хоолой хийсэн нь хөдөлмөр хөнгөвчилжээ

О. Пэрэнлэй

МАХН-ын Төв Хорооны 6 дугаар бүгд хурлын шийдвэрт зоригжсон манай аймгийн хөдөлмөрчид алдарт намынхаа 14 дүгээр их хурал, ардын хувьсгалын түүхт 40 жилийн ойг угтаж 3 дугаар таван жилийн төлөвлөгөөний ууган жил 1961 оны эхний хагас жилийн төлөвлөгөөг зүйлүүдийг биелүүлэхэд их амжилт оллоо.

Аймгийн хэмжээгээр гарсан төлийг 95,4 хувиар бойжуулж байна.

Энэ онд 21 мянга гаруй гектар атар газрыг хагалж тариалангийн үйлдвэрлэлд 60960 гектар газар эзэмшин нам засгийнхаа тавьсан зорилгыг нэр төртэй биелүүлэхэд хувь нэмрээ оруулав.

Тус аймгийн хөдөлмөрчид шургуу хөдөлмөрлөж ур тарианы тариалалтыг 12-14 хоногт багтаан 106,6 хувиар биелүүлж, хаврын тариалангийн төлөвлөгөөг САА-нууд 106,4 хувь, ХАА-н нэгдлүүд 114,4 хувиар биелүүлээ.

Үүний дотор Алтанбулаг, Баян, Угтаалшайдам зэрэг

мыг амжилттай байгуулахад бие хайрлахгүй хөдөлмөрчдийн үр дүн мөн.

Тус аймгийн эрлэхүг цогтой ажиллаж ардын хувьсгалын 40 жилийн ойг их амжилтаар угтлаа.

Аймгийн хэмжээгээр нийт үйлдвэрлэлийн эхний хагас жилийн төлөвлөгөөг 99,8 хувиар биелүүлсний дотор цахилгаан гаргалт 118,3 хувь, аймгийн хэвлэл 119,6 хувь, үйлдвэрийн хоршооллын үйлдвэрүүд 106,1 хувиар биелэгдэв.

Энэ бол эх орондоо социализм байгуулж байгаа манай нийгмийн манлайлагч хүч болсон ажилчин ангийн бүтэцтэй хөдөлмөр, авьяас чадварын үр дүн мөн.

Нам, засгаас ард түмний аж амьдрал, соёлын хэмжээг цуцалтгүй дээшлүүлэхийн тулд байнга авч байгаа арга хэмжээний үрээр тус аймгийн хөдөлмөрчдийн хувьд алдан авах чадвар хэлбэрлэлтгүй өслөө.

Аймгийн хэмжээгээр энэ хагас жилд жижиглэн худалдаалах бараа гүйлгээний төлөвлөгөөг 103,9 хувиар биелэлсний дотор ХБҮ газрын гүйлгээ 103,3 хувь, эмийн сангийн гүйлгээ 133,5 хувь, хэвлэл захиалга 2,2 дахингаар биелэгдэв.

Аймгийн хэмжээгээр 1 дүгээр улиралд бэлтгэх арас шир, ангийн үсний бэлтгэлийн 23 зүйлд 122 хувиас 8 дахингаар биелүүлж чанарын дээшлэлт гаргалаа.

Нэг малаас ашиглах ноосны гарцны хэмжээг улам нэмэгдүүлж, ноос бэлтгэлийн төлөвлөгөөг давуулан биелүүлэхийн төлөвлөгөө аймгийн хөдөлмөрчид шургуу шамдагхай хөдөлмөрчид байгатайгаар үрээр болон хөөвөр хялгас бэлтгэх төлөвлөгөө 109,1-104,4 хувь, хоньны ургын ноос тэмээний ноос 55,5 хувь, ямааны ноос, ноолуур 58,1-96,4 хувиар гүйцэтгэгдэж байна.

Бодын хөөвөр хялгас, ямааны ноолуурын төлөвлөгөөг сүүлийн 10 жилд биелүүлж байсан дутагдлыг өнгөрсөн оноос эхлэн тас

лаж биелүүлдэг заншлыг би болголоо.

Бүх сумд хөөвөр хялгасны төлөвлөгөөг давуулан биелүүлж ямааны ноолуурын төлөвлөгөөг 18 сум давуулан биелүүлсэн нь эдгээр сумдын нам улс олон нийтийн байгууллагуудын ажилчин, албан хаагчид, хөдөлмөрчид урьд жилүүдээс улам эрч далайтайгаар бүтээлтэй ажилласны дүн мөн.

Мал бэлтгэлийн ажлын нийтэд нь 2-7 хоногт багтааж аймгийн хэмжээгээр махны төлөвлөгөөг 100,1 хувиар биелүүлсэн бөгөөд энэ ажлыг Сэргэлэн, Дэлгэрхаан, Бүрэн зэрэг 20 сум 100-106,3 хувиар биелүүлжээ.

Манай нам засгаас тээвэр харилцаа холбоог цаашинд улам хурдан хөгжүүлэх талаар тавьж байгаа дайчин зорилтод зоригжсон тус аймгийн тээвэр холбоочид цуцалтгүй хөдөлмөрлөж эхний хагас жилд автобааз машин ашиглалтын коэффициент 075, лаан ашиглалтын коэффициент 090-д хүргэж хөдөлмөрийн бүтээмж 0,9 хувиар дээшлүүлсэн

## ОЙГООНИЙМ АМЖИЛТААР УГТАВ

## Прүүн асдоллор их амжилт

Сүргэвч сумын Алдар-хатгай нэгдлийн 1 дүгээр бригадынхан ардын хувьсгалын 40 жилийн ойг угтаж 1961 оны эхний хагас жилийн аж ахуй, соёл, төлөвлөгөөт зорилгыг дугаарлаад нь биелүүлэх түрэгний ажлааад хөдөлмөрийн өрнүүл амжилт гаргаж байгаа.

Энэ бригад жилийнхаа төлөлт 100 хувиар бойжуулж бодын хөөвөр хялгас, ямааны ноос ноолуур, уртын ноос бэлтгэх төлөвлөгөөг 100-107 хуви, мал бэлтгэхийн төлөвлөгөөг 101,3 хуви, 2 дугаар уулархын хөлдүү түүхий эд, ангийн үс, арьс шир бэлтгэх 23 нэр төрлийн төлөвлөгөөг 100-164 хувиар биелүүлжээ.

Энэ онд 44 нэгжээс 45 ботго бойжуулж тэмээ бүрээс 5,3 кг, ноос аарсан БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат тэмцэчин Дамдин, 12 үнэмнээс 13 тугал бойжуулсан салбарын Г. Дудам, 327 хоншоос 331 хурга, 82 ямаанаас 85 шигт бойжуулсан хоньчин өвчөөн Жамд, 95-100 ямаа самнаж ямаа бүрээсээ 350-375 г, ноолуур арасан Вадон, Чулуу нарны тэргүүний амжилтаар олон сайчууд төрөн гарч байгаа аж.

Одоо бригадын хэмжээгээр хоньчин сүү 10000, гүүний сүү 6000, үхрийн сүү 36000 литрийг ашиглаж 130 гаруй мянган төгрөгийн орлого оруулаад байна.

Д.Дондогдорж.

## ТЭРГҮҮНИЙ ЖОЛООЧ

Жаргалантын сангийн аж ахуйн авто машинны жолооч Бадрхын Лхавгаа нь 1956 онд шигээ ЗИС-5 машин авч их засваргүй 15000 км. явуулах үүрэг яваад амжилсан юм. Лхавгаа авсан үүрэг амжилттай биелүүлж ЗИС-5 машин ач их дунд засваргүй 20000 км. явуулжээ.

Энэ хутагтаандаа бензин 4800 литр, дугуй 12 ширхэг, мотор 1-ийг хэмнэж улсад 10 мянга шахам төгрөгийн ашиг оруулсан байна.

Жолооч Лхавгаа нь Намын 14 дүгээр их хурал, улс хувьсгалын 40 жилийн ойг угтаж 250000 км. явхаар үүрэг яваад зориг бадрхгүй ажиллаж байна.

П.Ориг.

ЗУРАГ ДЭЭР: Алтанбулаг сум, гол ийн салбарын таван зуут суурийн ажлагч Чимал, салбарын Рамбал, Вэлжид нар сүүгээ тушаахад бэлтгэж байна.

Д.Дондогдоржийн авсан гэрэл зураг

## Намын заалт амьдралд хэрэгжсээр байна

Манай нам улсын ба хуулийн нийт байгууллагууд хөдөлмөрийн олон түмний дэмжлэг туслахаатайгаар хуучин нийгмийн гэрэл болсон гэмт хэргийг арилгах ба түүнээс урьдчилан сэргийлэх талаар багагүй ажлуудыг зохиож ирвэ.

Үүний үр дүнд манай аймагт 1961 оны тэргүүн хагас жилийн 1960 оны тэргүүн хагас жилтэй зэрэгцүүлэн үзэхэд гэмт хэргийн гаралт 27,8 хувиар багасаж үүний дотор хуугийн гэмт хэргийг 11 хувиар багасав.

1960 оны эхний хагаст гэмт

хэрэг гаргаагүй сум байгаагүй бол энэ онд эхний хагаст Өндөрширээт, Бүрэн, Өнжүүл, Заамар нэгдлийн 6 сууцгалд гэмт хэрэг огт гаргасангүй.

Мөн Эрдэнэсант, Баяндэлгэр, Бөрнүүр, Баянжаргалан зэрэг 20 сум сангийн аж ахуй, нэгдэлд 1961 онд гэмт явдлын үйлдэл гаргаагүй зэрэг сайхан жишээ гарав.

Энэ бол гэмт хэргийн төмцөх тэмцэл нийтийн хөдөлгөөн болж олон түмний анхааралыг энэ зүгт татаж байгаа тод баримт мөн.

Ж.Үржинбалам



Алтанбулаг сумын Могой-Соог-хонь найрамдал нэгдлийн төвд БНАСА У.сын хүч хөрөнгөөр баригдаж ажил хууьсгалын 10 жилийн ойг өмнө ашиглаагад орсон 7 жилийн дула сургуулийн хөдөлмөрч байр

үндсэн дээр тонн км-ийн төлөвлөгөөг 110,9 хувиар, хүн км-ийн төлөвлөгөөг 117,0 хувиар биелүүлжээ.

Харилцаа холбооны ашигдалт үйлчилгээний эхний хагас жилийн төлөвлөгөөг 100-140 хувиар биелүүлсний дотор телефон харилцаа 140 хуви, радио зангилгааны төлөвлөгөө 115,3 хувиар биелүүлж 47 мянган төгрөгийн ашигтай ажиллав.

Манай холбоонд өөрийн хүчээр Угтаалцайд сумманд телефон харилцаа байгуулах ажлыг амжилттай хийж байгаа бөгөөд мөн Алтанбулаг, Баяндэлгэр сумд ба сөнөөгөрийн нөөгөөний зусланд радио зангилгааны байгуулаа.

Аймгийн соёл гэгээрэл, эрүүлийг хамгаалах байгууллагууд өсөн бэхжиж эхний хагас жилийн төлөвлөгөөт зорилтуудыг аймгийн соёлын орд, суурийн ба нүүдлийн кино, гэрэл зураг, урчуудын салбарууд, урлаг уран бүтээл, үйлчилгээний төлөвлөгөөг 100-118 хувиар биелүүлжээ.

Ерөнхий боловсролын сургуулиудад 4730 хүүхдийг

хамран суралцуулав.

Эмнэлгийн байгууллагуудын материаллаг бааз бэхжиж ард түмэнд нарийн эмнэлгийн үйлчилгээ улам ойртож эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээнүүд биелэжээ.

Ялангуяа аймгийн 1-25 насны бүх хүүд мэдрэлийн өвчнөөс сэргийлэх тариалгыг хийж хөдөлмөрдлийг нийгмийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ба эрүүлжүүлэх амил амжилттай явагдаж байна.

Аймгийн улсын төсвийн орлогын эхний хагас жилийн төлөвлөгөө 110,3 хувиар биелэсний дотор орлогын төлөвлөгөөг Алтанбулаг, Батсүмбэр, Заамар, Жаргалант сумд 6,1-9,8 хувиар давуулан биелүүлжээ.

Тус аймагт улсын хөрөнгөөр баригдах барилгууд түргэн баригдаж эхний хагас жилийн барилгын төлөвлөгөөг Зүүнхарагийн барилга конторы харьяа салбарууд 110,5 хувиар биелүүлжээ.

Манай аймагт хот орныг тохижуулах, нийгэм хангамжийн ба соёл ахуйн ба

рилгуудыг ажилчин албан хаагчдын хүч хөдөлгөөнөөр хийж ажил ид өрнөж ардын хувьсгалын 40 жилийн ойн өмнө нийтийн номын сан, орон нутгийг судлах кабинет, 90 хүүхдийн багтаамж бүхий нээлзэргийн зуслан, 100 хүүхдийн багтаамж бүхий тоног төхөөрөмжтэй аяллын барилгууд ашигдалтайд орж 48 айлын орон сууц, биений тахирын заал, 20 машинны нэгдсэн гараан зэрэг нэлээд барилгуудын гол ажилууд амжилттай хийгдэж байна.

Ардын хувьсгалын 40 жилийн ойг угтаж энэ оны эхний хагас жилийн төлөвлөгөөт зорилтуудыг амжилттай биелүүлэхийн төлөө санаачлага, бүтээл хөдөлмөрөөрөө шалгарсан тэргүүний хүмүүсийн эгнээ өдрөөс өдөрт өсч байна.

Социалист урлагчдын нийлээ дээд хэлбэр болсон социалист хөдөлмөрийн бригадын төлөө хөдөлгөөн өрнөж олоо тус аймагт 700 гаруй хүнийг хамарчээ.

Социалист хөдөлмөрийн бригад хөр, социалист хөдөлмөрийн төлөө бригад 48,

сэхээтний социалист нөхөрлөл 20 байгуулагдан амласан үүргээ нэр төртэй биелүүлэхийн төлөө шамлан ажиллаж байна.

Малын төл хүлээн авах ажилд хэлбэр ба хөрөнгийн аргаар бойжуулах давшилттай аргыг хэрэглэн 1961 онд 496 хурга, 60 ямаанаас 60 шигт бойжуулсан Заамар нэгдлийн хоньчин Алтангэрэл, 480 хоншоос 480 хурга бойжуулсан Тариат сумын Батхөгжил нэгдлийн хоньчин Дугар, 22 нэгжээс 22 ботго бойжуулсан Баянбаргаг сумын Баян-амьдрай нэгдлийн тэмээчин Тавхай, нутгийн үүхдрийн 15 гуйнш үнээ бүрээс 1000 литр сүү саахаар авсан үүргээ биелүүлэхийн төлөө чалалтай ажилдаж байгаа Лун сумын Энхтүүл нэгдлийн салбарын БНМАУ-ын их хурлын депутат Дулмаа, малын өвчний байдалаа сулаага хийж шигт малд уларал дугам эрүүд мөндийн үзлэг явуулж урьдчилан сэргийлдэг Эрдэнэсант сумын малын их өмч Дамдингомоо, шигтэн сүү ашиглах усны уургаар өтгөрүүл-

сэн ааруул, хуурай сүү, санаачлан хийсэн Өндөрширээт сумын сүү тосны занварын мастер Дамба, 1961 оны эхний хагас жилийн торхоо нэг сарын өмнө 130 хувиар биелүүлсэн хүнсний комбинатын номынчид Дэлгор, 1961 оны хагас жилийн торхоо нэг сарын өмнө 111 хувиар биелүүлсэн Баянчандмань сумын ХБ ангийн дэлгүүрийн худалдагч Цэрэнханд, нэрм төлөвлөгөөгөө 216 хувиар биелүүлсэн Баянчандмань сумын артелийн номынчид Вадсанжав, яцаа тээврийн эхний хагас жилийн төлөвлөгөөгөө 191,8 хувиар биелүүлж 561 литр бензин хэмнэсэн 13 дугаар баазын жолооч П. Содномпил, үр ашигч ба хордуулагч малын санаачлан хийсэн хөдөлмөрийн бүтээлийг нэмэгдүүлж аж ахуйдаа 8952 төгрөгийн ариулах хэмнэлт гаргасан Батсүмбэрийн сангийн аж ахуйн техникч Намба, Л.В. мотороор үйлчилж байсан радио үзэлийг ашигтайгаар өөрчилж эх орон хүлээн

(Төгсгөл нь 4 дүгээр нүүрт)

